



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 05 сарын 04 өдөр

Дугаар 141

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө олж авах зөвшөөрөл
олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 86 дугаар тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 3.1, 3.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын албан ажлын хэрэгцээнд зориулан нийт 120,000,000.00 (нэг зуун хорин сая) төгрөгөөр автобус, микроавтобусыг Монгол улсын 2019 оны төсвийн хөрөнгө оруулалтаар олж авахыг зөвшөөрч, автомашины техникийн үзүүлэлт, үнийн дээд хязгаарыг хавсралтаар баталсугай.

2. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Өнөрбаяр, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга О.Алтансүх нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:


2.1. Үндсэн хөрөнгө худалдан авах ажлыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2019 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Б. ГАНБАТ

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА


А. АРИУНБОЛД

0000285

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2019 оны 5 дугаар сарын 04-ны өдрийн
14.1 дугаар тогтоолын хавсралт



Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн
газрын олж авах автомашин

Д/д	Хөрөнгийн нэр	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Тоо ширхэг	Худалдан авах үнийн дээд хязгаар (төгрөг)
1	Суудлын /автобус/, хөдөлгүүрийн багтаамж 12000 cc хүртэл, суудлын тоо 45	63,000,000.00	1	63,000,000.00
2	Суудлын /микроавтобус/, хөдөлгүүрийн багтаамж 2500 cc хүртэл, суудлын тоо 12	57,000,000.00	1	57,000,000.00
	Нийт дүн		2	120,000,000.00 (нэг зуун хорин сая)